



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 424

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтооолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн албан ажлын хэрэгцээнд зориулан 73,000,000.00 (далан гурван сая) төгрөгт багтаан автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн захирал Р.Отгонбаяарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайландаа тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА
Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Д.НАРАНГЭРЭЛ

30611

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 09 дугаар сарын 08.
-ны өдрийн 12 дугаар тогтоолын
хавсралт

**Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн
Монгол-Японы эмнэлгийн худалдан авах автомашины техникийн үзүүлэлт,
үнийн дээд хязгаар**

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар
1	Суудлын автомашин /суудлын тоо 5, 1600 cc хөдөлгүүрийн багтаамжтай/	ш	1	73,000,000.00
	Нийт үнэ		1	73,000,000.00 (далан гурван сая)